

МОНГОЛ УЛСЫН “БАЙНГА ТӨВИЙГ САХИХ” БОДЛОГО ХИЙГЭЭД ТҮҮНИЙ ХЯТАД УЛСАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Э.Наран¹

Монгол Улс нь газар зүйн байрлалын хувьд Хятад, Оросын дунд оршдог далайд гарцгүй эх газрын түгжигдмэл улс гэдгийг хүн хүнгүй мэднэ. Гэвч Монгол Улс нь огтхон ч түгжигдмэл бус бөгөөд өнөөгийн байдлаар дэлхийн 193 орны 184-тэй нь дипломат харилцаа тогтоосон ажээ. Монгол Улс хүн ам, эдийн засгийн ерөнхий багтаамжийн хувьд жижиг улс ч гэлээ их гүрнүүдийн хараа, анхаарлыг өөртөө татсаар ирсэн юм. Тус улс “олон тулгуурт” гадаад бодлогынхоо хүрээнд Хятад, Орос, Америк, Япон, Энэтхэг, Өмнөд Солонгос болон Европын Холбоо зэрэг дэлхийн том улс гүрнүүд, олон улсын байгууллагатай сайн харилцаа явуулдаг. Нийгмийн тогтолцооны шилжилт хийснээс хойш Монгол Улс гадаад бодлогын чиглэлээр олон чухал үр дүнд хүрснийхээ үндсэн дээр бодлогын зохицуулалт хийж, төгөлдөржүүлж ирсэн юм. 2015 оны 9 дүгээр сард Монгол Улс “Байнга төвийг сахих” бодлого дэвшүүлэн тавьсан нь олон улсын хамтын нийгэмлэгийн анхаарлыг ихээр татах болжээ.

Нэг. Монгол Улсын идэвхтэй гадаад харилцаа

2016 оны эхний саруудад Монгол Улс нь их гүрнүүдтэй ойр ойрхон харилцах болсноос тус улсын гадаад харилцааны идэвхжлийг

¹ БНХАУ, ӨМИС-ийн Монгол Улс судлалын хүрээлэн, доктор, профессор

*Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого хийгээд түүний
Хятад улсад үзүүлэх нөлөө*

харж болохоор байна. харилцааны идэвхтэй байдлыг харж болохоор байна.

БНХАУ, ОХУ-тай харилцаж буй нь

Монголын талын санаачлагаар Хятад, Монгол, Орос гурван улсын төрийн тэргүүн нарын байнгын уулзалтын механизм бий болов. Хэд хэдэн удаагийн уулзалтын явцад гурван улсын төрийн тэргүүн нар “Хятад, Монгол, Оросын гурван талт хамтын ажиллагааны дунд хугацааны замын зураг”-ийг эхлүүлэхээр нэгдсэн ойлголцолд хүрсэн нь Хятадын “Шинэ Торгоны замын эдийн засгийн бүс”, Оросын “Евразийн холбоос”, Монгол Улсын “Талын зам” санаачлагуудыг уялдаатай хэрэгжүүлэх, “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ыг хамтран байгуулахад чиглэсэн чухал алхам болов. Гурван талын 3 дахь удаагийн дээд түвшний уулзалт энэ оны 6 дугаар сард Ташкент хотноо болсон ШХАБ-ын дээд түвшний 16 дахь удаагийн уулзалтын хүрээнд зохион байгуулагдав. Энэ үеэр гурван улсын төрийн тэргүүн нар болох БНХАУ-ын улсын дарга Си Зиньпин, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нар уулзахдаа худалдаа-эдийн засаг, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал, хил орчмын бүс нутаг зэрэг салбарын хамтын ажиллагааг эргэн дүгнэж, дээрх хамтын ажиллагааг цаашид үргэлжлүүлэн хөгжүүлэхээр тохиролцсоны зэрэгцээ “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг батлан гарын үсэг зурахад байлцав. Энэхүү ахиц дэвшил бол гурван талын яриа хэлэлцээний бас нэгэн чухал үр дүн болов. Дараа нь гурван улсад тулгамдаж буй асуудал бол нэгдсэн зөвшилцөлд хүрээд байгаа эдийн засгийн коридор байгуулах төлөвлөгөөг идэвхтэй, түргэн хугацаанд хэрэгжүүлэх явдал бөгөөд Монгол Улсын хувьд хоёр хөрштэйгээ хамтран зам тээвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг урагшлуулах, хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь тулгамдсан зорилт болж байна.

4 дүгээр сарын дундуур Оросын Гадаад хэргийн сайд С.Лавров нөр их ажлын хажуугаар цаг гарган Монгол Улсад айлчилсан нь Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн харилцааны явцыг идэвхжүүлэхэд түлхэц үзүүлэв. Айлчлалын үеэр С.Лавров хоёр улсын

эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбар дахь хамтын ажиллагааг улам бэхжүүлнэ хэмээн мэдэгдсэн юм. Түүнчлэн Ерөнхийлөгч В.Путин Монголын 174.2 сая ам.долларын өрийн 97.8%-ийг чөлөөлөх хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой болж, Монгол Улс нь ОХУ-аас дахин зээл авах боломжоор хангагдав. Орос, Монголын Засгийн газар хоорондын зөвлөлдөх уулзалтын үеэр оросын тал монголын талд 50-100 тэрбум рублийн хөнгөлөлттэй зээл олгохоор амалсан гэсэн мэдээлэл байна. Тус хоёр улсын аюулгүй байдлын хамтын ажиллагааны талаар Оросын Гадаад хэргийн сайд С.Лавров хэвлэл, мэдээллийнхэнд хандан: *“Бидний найрсаг харилцаат Монгол Улсын дотоод хэрэгт гадаад хүчин хөндлөнгөөс оролцохыг таслан зогсоохын төлөө хөрш орнууд болох Орос, Хятадын зүгээс бүх хүч бололцоогоо харамгүй дайчлах болно”*² хэмээн мэдэгдсэн байна.

АНУ-тай харилцаж буй нь

Монгол Улс дэлхийн тэргүүлэгч их гүрэнтэй “гуравдагч хөрш”-ийн харилцаатай билээ. 6 дугаар сарын 4-ний өдөр Хятадыг багтаасан нийт 47 улсын 2000 гаруй хүн оролцсон Монгол, Америкийн олон улсын хамтарсан цэргийн сургуулилалт болсны маргааш нь буюу 6 дугаар сарын 5-ны өдөр АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга (цаашид ТНБД гэх) Ж.Керри Монгол Улсад дөрөвхөн цагийн богино хугацааны айлчлал хийв. Энэ нь Монгол Улсад нийгмийн тогтолцооны шилжилт явагдсанаас хойш Америкийн ТНБД-ын 5 дахь айлчлал болов. Өмнө нь Америкийн ТНБД Ж.Бэйкер 1991, 1992 онд, М.Олбрайт 1998 онд, Х.Клинтон 2012 онд тус улсад айлчилч байжээ. Ж.Керри Монгол Улс бол “ардчиллын баян бүрд”, “хариуцлагатай дэлхийн иргэн” хэмээн магтаад, харилцан зөрчилтэй хоёр хөрштэйгээ төвийг сахих байдлаа хадгалах хэрэгтэй хэмээн монголчуудад сануулсан билээ. Эдийн засгийн хамтын ажиллагааны хувьд 2007-2013 онд Америкийн зүгээс 285 сая ам.долларыг Монгол Улсад Мянганы сорилтын сангийн хүрээнд олгож байсан юм. Тэгвэл энэ удаа тус улсыг Мянганы сорилтын сангаас дахин хүртэгч улсад хамруулсан байна.

² Монголын “Өдрийн сонин”-ы 2016.04.14-ний өдрийн дугаарт гарсан Оросын ГХ-ийн сайд С.Лавров Монгол Улсад хийх айлчлалынхаа өмнө сэтгүүлчдэд өгсөн ярилцлагын тэмдэглэл

*Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого хийгээд түүний
Хятад улсад үзүүлэх нөлөө*

Япон улстай харилцаж буй нь

Олон жилийн турш Монгол, Японы харилцаа сайн хөгжиж иржээ. Ялангуяа худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарын харилцаа хамтын ажиллагаа тогтвортой хөгжиж байгөө бөгөөд Япон нь Монгол Улсын хамгийн том хандивлагч орон болох юм. Энэ оны 6 дугаар сарын эхээр тухайн үеийн УИХ-ын дарга З.Энхболд Японд ажлын айлчлал хийж, тус хоёр улс нүүрс хийжүүлэх болон хагас коксжсон түлш үйлдвэрлэх талаар хамтын ажиллагааг өрнүүлэхээр тогтсон юм. Түүнчлэн тус хоёр улсын хооронд байгуулагдсан “Эдийн засгийн түншлэл”-ийн хэлэлцээр 6 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба энэхүү хэлэлцээрийн хүрээнд Японы 9300 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, Монголын 5700 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн харилцан импортын татвараас чөлөөлөгдөв. Цаашид Монгол, Японы худалдаа, эдийн засгийн харилцаа хурдацтай хөгжих чиг хандлагатай байна.

Өмнөд Солонгостой харилцаж буй нь

Энэ оны 5 дугаар сарын дундуур Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Өмнөд Солонгост айлчлав. Айлчлалын хүрээнд талууд дэд бүтэц, эрчим хүч, ашигт малтмал болон бусад салбарт 300 сая ам.долларын хамтын ажиллагааны төслүүд хэрэгжүүлэхээр болж, баримт бичгүүдэд гарын үсэг зуржээ. Монгол Улс нь Умард, Өмнөд Солонгосын аль альтай нь сайн харилцаатай юм. Талуудын хоорондох хөдөлмөрлөх хүчний хамтын ажиллагааны хувьд Монгол Улс нь жил бүр Умард Солонгосоос хэдэн мянган ажиллах хүч авдаг (Монгол дахь нийт гадаадын ажиллах хүчний 24 хувийг эзэлдэг) бол харин Өмнөд Солонгос руу хэдэн мянгаас хэдэн арван мянган ажиллах хүчнийг илгээдэг байна.

Энэтхэгтэй харилцаж буй нь

Монгол Улс нь Энэтхэгтэй хүмүүнлэгийн салбарын уламжлалт хамтын ажиллагаатай бөгөөд тус хоёр улс харилцан биенээ “оюун санааны хөрш” хэмээнэ. Сүүлийн жилүүдэд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-технологийн салбарын хамтын ажиллагаа эрчимтэй

хөгжиж байна. Энэ оны 4 дүгээр сараас Энэтхэгээс Монголд 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох хэлэлцээрийг талууд хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ мэтээр Монгол Улс ойр давтамжтайгаар дээрх их гүрнүүдтэй өрнүүлж буй хамтын ажиллагаа нь олон улсын анхаарлыг тус улсад хандуулж, байр суурийг нь дээшлүүлж, нөлөө хүрээг нь нэмэгдүүлэх болсон нь тус улсын өнөөгийн үүсээд байгаа эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг гэтлэн давахад нааштай үр нөлөө үзүүлж буйд эргэлзэх асуудалгүй юм.

Хоёр. Монгол Улсын төвийг сахих бодлого

Монгол Улс 1994 онд “Гадаад бодлогын үзэл баримтлал” буюу “олон тулгуурт” гадаад бодлого гаргаж, улмаар 2011 онд түүнээ шинэчлэн гаргахдаа “олон тулгуурт” гэсэн гол тулгуур дээрээ “гуравдагч хөрш” хэмээх заалтыг нэмж оруулсан билээ. Улмаар 2015 оны 9 дүгээр сард Монгол Улс “Байнга төвийг сахих” бодлогыг дэвшүүлэн тавьж, түүнээ “олон тулгуурт” гадаад харилцааны үргэлжлэл, зүй ёсны хөгжил замнал хэмээн мэдэгдэж байна. Өнөөдөр Монгол Улс “Байнга төвийг сахих” байр сууриа хууль ёсоор баталгаажуулахаар идэвхийлж, Зүүн Ази дахь цорын ганц “Байнга төвийг сахисан улс” болох бэлтгэлээ базааж байна. Монгол Улс энэхүү гадаад бодлогын чиглэлээ өндөр хэмжээнд чухалчлан үзэж байгаа төдийгүй уг бодлого нь олон улсын хамтын нийгэмлэг болон холбогдох улс орнуудын анхаарлыг ч татаад байна.

1. Төвийг сахисан бодлого гэж юу вэ?

Төвийг сахисан улсыг дотор нь дайны үеийн Төвийг сахисан улс, Байнгын төвийг сахисан улс гэж хоёр хувааж үздэг байна.

Дайны үеийн Төвийг сахисан улс гэдэг нь олон улсын хэмжээнд дайны үед төвийг сахих байр сууриа хадгалж буй улсыг хэлдэг.

Байнгын төвийг сахисан улс гэдэг нь гэрээг эсхүл нэг талын гаргасан тунхаглалыг үндэслэн тайван болон дайны цагийн алинд ч байнга төвийг сахих бодлого барьж буй улсыг хэлнэ.

Монгол Улсын “Байнга төвийг сахих улсын байр суурийг “шинэ

*Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого хийгээд түүний
Хятад улсад үзүүлэх нөлөө*

цаг үе дэх, идэвхтэй төвийг сахисан бодлого” хэмээн томъёолж байна. (Монгол Улсын Геополитик судалгааны хүрээлэнгийн захирал Д.Мягмар)

2. “Байнга төвийг сахисан улс”-ын бодлого өмнөх гадаад бодлогоос ямар ялгаатай вэ?

Юуны өмнө Монгол Улсын 1994, 2011 оны Гадаад бодлогын үзэл баримтлалын гол чиглэлүүдийг харъя.

А. 1994 оны 6 дугаар сард гаргасан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын “Олон тулгуурт” гэдэгт:

Нэгд, ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцааг хадгалах нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болно. Гэхдээ аль нэг талыг дангаар түшиглэхгүй, тэнцвэртэй харилцах бодлогыг тууштай баримтлана;

Хоёрт, АНУ, Япон, ХБНГУ, Энэтхэг зэрэг өрнө, дорнын улс орнуудтай найрсаг харилцааг хөгжүүлнэ

Гуравт, Зүүн хойд Ази, Төв Азийн чиглэлийн хамтын ажиллагааг чухалчлана;

Дөрөвт, НҮБ болон түүний олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлнэ;

Тавд, Хуучин социалист улс орнуудтай найрсаг харилцаагаа хадгална (Зүүн Европ, Куба, Умард Солонгос);

Б. 2011 оны 2 дугаар сард гаргасан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Гуравдагч хөрш” гэдэгт:


ОХУ, БНХАУ-тай харилцах нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл бөгөөд гадаад бодлогын дараагийн чиглэл нь АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс орнууд, эвсэл холбоодтой гуравдагч хөршийн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ гэж заажээ.

Дээрхээс дүгнэж үзэхүл, 1994, 2011 оны үзэл баримтлалд хоюуланд “олон тулгуурт”, эвсэлд үл нэгдэх, нээлттэй бодлого гэдгийг үзэл баримтлал болгосон бол харин 2011 оныхт “Гуравдагч хөрш” гэдэг ойлголтыг хууль зүйн үүднээс томъёолж буулгасан байна.

В. 2016 онд тус улсын дэвшүүлсэн “Байнга төвийг сахих бодлого” бол “олон тулгуурт” гадаад харилцааны үргэлжлэл, зүй ёсны хөгжил замнал нь бөгөөд үндсэн тэнхлэг нь өөрчлөгдөөгүй “олон тулгуурт” бодлого болох юм.


Тэгвэл эцсийн дүндээ ямар ялгаатай вэ гэдгийг зураг дүрслэлээр тайлбарлая.

1. Нэг төвт дугуйнууд - concentric circles (1994, 2011 оны “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”)



Нэг төвт дугуйнуудын төвөөс дугуй бүрийн тойргийн хязгаар хүргэлх зай нь харилцан адилгүй.

2. Байнга төвийг сахих - Тойргийн төв ба тойргийн хязгаар хоорондын харилцаа



*Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого хийгээд түүний
Хятад улсад үзүүлэх нөлөө*

Дугуйн радиус (R) нь ямагт адил байдаг, ижил зайтай. Дугуйн төвөөс тойргийн аль ч цэг хүртэлх зай ижил, өөрөөр хэлбэл Монгол Улс нь бүх улс орнуудтай ижил зайтай оршино. (Жишээлбэл 10 улстай). Онолын хувьд тэргүүлэх чиглэл болон хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх, тав дахь чиглэл гэж байхгүй.

Гурав. Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлогын Хятадад үзүүлэх нөлөө

Монгол Улс нь Хятадын хойд хэсэгт орших ойрын хөрш бөгөөд тус улсын аливаа үйл хөдлөл Хятадад их, бага хэмжээгээр нөлөөлж байдаг нь тодорхой. Тиймдээ ч Монгол Улсын дэвшүүлсэн “Байнга төвийг сахих” бодлого нь Хятад улсын гадаад харилцаанд шууд бус тусгал нөлөө үзүүлэх нь гарцаагүй.

Нэгдүгээрт, Үндэсний аюулгүй байдлын өнцгөөс харвал, Монгол Улс нь “Байнга төвийг сахисан” статустай болвол Хятадын хойд талын аюулгүй байдалд “хамгаалалтын хөшиг” буй болгож байгаатай дүйцнэ.

Хятадын эргэн тойрныг нийтэд нь харахад хойд тал нь харьцангуй амар тайван байдаг. БНХАУ нь Монгол Улс, ОХУ-тай “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа” тогтоосон бөгөөд харьцангуй эрт хилийн гэрээ байгуулж, найрсгаар харилцахаа илэрхийлсээр иржээ. Ялангуяа Хятад, Монгол хоёр улсын харилцаа түүхийн хамгийн таатай цаг үедээ явж байгаа юм.

Хэрэв Монгол Улс “Байнга төвийг сахисан улс” болвол Хятадын умард талд бүс нутгийн бус улс орнууд нэвтэрч орохоос болгоомжлох Хятадын талын болгоомжлолыг зөөлрүүлж болох юм.

Хоёрдугаарт, Эдийн засгийн өнцгөөс харвал, Хятад улсын Монгол Улстай явуулж буй хамтын ажиллагаа нь олон өрсөлдөгчтэй тулгарахын зэрэгцээ бас олон боломжоор хангагдаж болох юм. “Байнга төвийг сахисан улс”-ын статус нь Монголын эдийн засгийн хөгжилд шинэ боломжуудыг бий болгоно гэсэн үг. Олон улсын эрх зүйн хувьд олон улсын маргаан, зөрчилдөөнөөс ангид улс нь аюулгүй, таатай орчинд хөрөнгө оруулахыг эрмэлздэг хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах нь тодорхой. Монгол Улс хэдийгээр ашигт малтмалын асар их нөөцтэй, дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой

ч хөгжлөөр дутмаг юм. Үүнийг энэхүү өгүүллийн эхний хэсэгт Монгол Улсын бусад улс орнуудтай харилцаж байгаа байдлаас, холбогдох улс орнууд ч ээлж дараалан Монгол Улсад их хэмжээний эдийн засгийн тусламж, хөнгөлөлттэй зээл олгож байгаа байдлаас ч харж болно.

Хятад нь олон жил Монголын хамгийн том худалдааны түнш, гол хөрөнгө оруулагч улсын байр сууриа хадгалсаар байна. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын дунд Хятадын хөрөнгө оруулалттай компани аж ахуйн нэгжийн тоо 6000 гаруй байгаа нь тоогоороо тэргүүлж байгаа. Монгол “Байнга төвийг сахисан улс” болсны дараагаар гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тоо нэмэгдэх хандлага ажиглагдана. Энэ нь Хятадын гадаад хөрөнгө оруулалт, “Нэг бүс, нэг зам” санаачлагын Монгол дахь хэрэгжилт болон Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад таатай боломж бүрдүүлж өгөх юм. Мөн тодорхой сорилт авчрах нь мэдээж. Ялангуяа монголчуудын туйлын таатай ханддаг Япон улсын тэргүүний технологи, асар баялаг хөрөнгийг Монгол руу ихээр татах болно. Энэ нь Хятадын хувьд өрсөлдөөнийг бий болгох нь зайлшгүй зүйл юм. Монгол Улсын аливаа улс орнуудтай эрх тэгш хамтран ажиллах үйл явцын дунд бусдаас туршлага, мэдлэг солилцох боломжийг Хятад улс ч олж авна.